



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:


1. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах журам”-ын хоёрдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 2.2 дахь хэсгийг нэмсүгэй.

“2.2. Саналын хуудсыг хэвлэх аж ахуйн нэгж нь үнэт цаас хэвлэх тусгай зөвшөөрөлтэй, тагнуулын байгууллагаас олгосон аюулгүй байдлын гэрчилгээ бүхий хуулийн этгээд байх бөгөөд саналын хуудас нь Сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжид ашиглагдах тусгай шаардлага хангасан байна.”

2. Мөн журмын 2 дугаар бүлгийн “2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12” гэсэн дугаарыг “2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12, 2.13” гэж тус тус өөрчилсүгэй.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000025